

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогтцэций сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/14/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn Өмнөговь аймаг Даланзадгад сум 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Сүрэнжаргал Утас: 70533552 Цахим хаяг: Surenjargald@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Г.БАЦМАА ТАНАА

2022.03.24 № 268

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цогцэций сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цогцэций сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-03-24\№268

013020412

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2021.12.31
Эргэлтийн хөрөнгийн дүн	3,625.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	32,997.2
Нийт хөрөнгийн дүн	36,622.6
Нийт өр төлбөрийн дүн	3,356.9
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	33,265.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	36,622.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан	
Үйл ажиллагааны орлогын дүн	13,890.7
Үйл ажиллагааны зардлын дүн	12,272.2
Үйл ажиллагааны үр дүн	1,718.5
Үйл ажиллагааны бус үр дүн	1,366.9
Үйл ажиллагааны нийт үр дүн	1,366.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,728.6
Тайлант оны үр дүн	1,366.9
Эцсийн үлдэгдэл	33,265.7
Мөнгөн гүйлгээний тайлан	
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	11,143.6
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	9,701.7
Үйл ажиллагааны ЦМГ	1,441.9
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-1,267.4
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	174.5
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	174.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,617.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,791.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан	
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	7,726.6
Урсгал зардал	6,483.1
Хөрөнгийн зардал	1,243.5
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	8,189.4
Орон нутгийн төсвөөс	5,598.9
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,504.7
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	14.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	71.8

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цогтцэций сумын Засаг даргын зорилго нь: “Монгол ёс заншил зан үйлээ дээдэлсэн боловсролтой чинээлэг иргэдтэй эдийн засгийн өндөр чадавхтай Монгол Улсын хөгжлийн тулгуур хот болон хөгжинө” гэж тодорхойлсон гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” хүчингүй болж, 2021 оны 190 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан тушаалыг тайланд онд шинээр мөрдөгдөж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхий нийтийг хамарсан Ковид 19 цар тахалтай холбоотойгоор өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж орон нутгийн нөөц хөрөнгө данс ЗДТГ-ын төсвөөс 234.1 сая төгрөгийн өртөг бүхий ариутгалын бодис, хамгаалах хувцас, хэрэглэл, тээвэр шатахуун, хоол, урамшууллын зардал гаргасан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр 1,243.4 сая төгрөгийн 17 ажил хийгдсэн бөгөөд тухайн ажлуудыг данс бүртгэлд тусгаж ажилласан ч барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, эд хогшлын чанар, хэрэгжилтийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэлт өгөх боломжгүй байлаа.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих 175 мэдээллээс хугацаандаа оруулсан 170 мэдээлэл, хугацаа хоцроон оруулсан 5, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сум хөгжүүлэх сангийн зээлийн зарцуулалтыг дэлгэрүүлж үзэх шаардлагатай байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 7,207.3 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 24.4 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 163.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж ажиллаа.

7.1 Залруулсан алдаа

Аудитаар Үндсэн хөрөнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн дүн 6,948.9 сая төгрөгөөр, бараа материалын дүн 58.2 сая төгрөгөөр, санхүүгийн үр дүнгийн тайлангийн элэгдлийн зардал 12.3 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгагдсаныг залруулсан

7.2 Албан шаардлага

Засаг даргын нөөц сангаас төсвийн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэлд 14.4 сая төгрөгийн хөрөнгө, сумын эрүүл мэндийн төвд 10.0 төгрөгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл олгосон, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг бодитой тооцсон эсэхийг нотолсон баримт, төлөвлөгөө байхгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3 дугаар хэсгийн 3.1.2 "урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх", 3.1.4 "арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг зөв, бодитой тооцсон эсэхийг холбогдох норм, норматив, тариф, бусад баримтаар нотолсон байх", 3.1.5 "хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шийдвэрийн төсөлд хавсаргасан байх" дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

7.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 163.4 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж хэвшүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

[illegible]